

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
(2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр)

2024 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023 он)	Зорилтот түвшин (2024 он)	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Хувь
	1	2	3	4	5	6	7
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1: Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4							
1.	Зорилт 1: Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.1						
1.1	Арга хэмжээ-1: Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг үргэлжлүүлэн гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх	Нийслэлийн төсөв 290.0	Жуулчны мэдээллийн төв, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	7 төв, 10,741 хүн	8 төв, 15,000 хүн	Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилтын хүрээнд үндэсний онцлог бүхий жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг Жанжин Д.Сүхбаатарын талбайд шинээр байгуулж 2024 оны 10 дугаар сараас үйл ажиллагаагаа эхлүүллээ. Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг 8 байршилд буюу Нийслэлийн Засаг захиргааны IV байр, “Төв шуудан”, жанжин Д.Сүхбаатарын талбай, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төвүүд болон “Тэрэлж Монгол олле”, “Хонхор тосгон Монгол олле”, “Сөүлийн гудамж Монгол олле” төвүүдийг тогтмол болон улирлын чанартай ажиллуулан 16,180	100

						хүнд, зохион байгуулсан үзэсгэлэн, эвент арга хэмжээнүүдийн үеэр жуулчны мэдээлэл сурталчилгааны цэгийг ажиллуулж 40,580 хүнд буюу нийт 56,760 гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.	
1.2	Арга хэмжээ-2: Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын шинж чанартай арга хэмжээнүүдийг зохион байгуулах	Нийслэлийн төсөв 957.0	Арга хэмжээ, оролцогч, үзэгчдийн тоо	10 арга хэмжээ, 131,500 хүн	15 арга хэмжээ, 150,000 хүн	Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадам, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Франц соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Талын салхи” олон улсын мото наадам, “Плэйтийм” олон улсын хөгжмийн наадам, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд фестиваль”, “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”, “Японы соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Гранд тур” зэрэг аялал жуулчлалын 15 арга хэмжээг зохион байгуулж нийт гадаад, дотоодын 352,050 хүн үзэж сонирхсон.	100

1.3	Арга хэмжээ-3: “Сити тур” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Нийслэлийн төсөв 60.5	Аялалд хамрагдсан хүний тоо	5052	5500	“Сити тур” төслийн хүрээнд жуулчдад зориулсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон хот орчмын түүх, соёлын дурсгалт газрууд, ахуй амьдрал, ёс заншил, байгальтай танилцах болон үзвэр, худалдаа үйлчилгээг багтаасан маршрутуудыг шинэчлэн гаргаж 82 удаагийн аяллаар нийт гадаад, дотоодын 7,380 хүнийг хотын аялалд хамрууллаа.	100
1.4	Арга хэмжээ-4: Жуулчдад зориулсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх	Нийслэлийн төсөв 125.0	Бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо	1	1	1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Арван Долоо Гучин Долоо Энтертайнмент” ХХК-тай хамтран Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон хөгжүүлэх, зорин очих газрыг нэмэгдүүлэх зорилгоор “Плэйтайм” тогтвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төслийг Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт эхлүүлэн 500,000 м.кв талбай бүхий газарт 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгууламжийн гадна талын 5000 м урт хашаа, 2500 м урт тусгаарлах хашаа барьж, цахилгаан, цэвэр усны эх үүсвэрийг шийдвэрлэн ариун цэвэр болон хог хаягдлын байгууламж, тохижилт бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж төслийн талбайд 58,000 ширхэг мод тарих ажлыг зохион байгууллаа. 2.Улаанбаатар хот болон хот орчимд эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, жуулчдын зорин очих газар болон маршрутын тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын мэдээллийн сан үүсгэх, дотоодын	70

						<p>аялагчдад зөв зохистой аялах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх ажлын хүрээнд хот орчмын байгалийн өвөрмөц тогтоц, үзэгдэл, зэрлэг амьтад, жигүүртэн шувууд, цэцэг ургамал, түүх соёлын дурсгалт газрын гэрэл зургийг авах 15 маршрутыг гаргаж, мэдээллийн самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулах ажлууд хийгдэж байна. Тухайлбал Бэлхийн амаас- Батсүмбэр хүртэл 15 км, Шарга морьт зусланд 7,5 км, Бэлхийн амны хүннүгийн цогцолборт 6,5 км, Их баян зусланд 7,5 км аяллын маршрутыг шинэчлэн гаргаж замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулах ажлыг гүйцэтгэж байна.</p>	
1.5	<p>Арга хэмжээ-5: Аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилгоор өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх</p>	-	<p>Хөнгөлөлтөд хамрагдсан байгууллагын тоо</p>	13	20	<p>Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах, өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор www.tourism.ub.gov.mn цахим хуудсаар дамжуулан “Өвлийн улирлын хямдрал” цэс аяныг зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 9 салбарын 62 аж ахуйн нэгж, байгууллага 500 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 10-50 хувь хүртэл хөнгөлөлттэй үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүлсэн.</p>	100
2.	<p>Зорилт 2: Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.2</p>						

2.1	<p>Арга хэмжээ-6: Улаанбаатар хотын танилцуулга сэтгүүл, цахим сэтгүүл, газрын зураг, хөтөч ном зэрэг тараах материал шинэчлэн гаргах</p>	Нийслэлийн төсөв 90.0	Материалын тоо	15,500	10,000	<p>Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах зорилгоор Улаанбаатар сэтгүүлийг 6 орны хэлээр (Англи, Герман, Япон, Солонгос, Орос, Хятад) 11,000 ширхэг, Улаанбаатар хотын хөтөч ном (Guide book) 2,000 ширхэг, жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг (City map) 5,000 ширхэг, “Жим сэтгүүл” 1,000 ширхэг нийт 4 төрлийн 19,000 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, консулын газрууд, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, зөвлөгөөн, эвент арга хэмжээнүүдэд тарааж Улаанбаатар хотыг сурталчилсан.</p>	100
2.2	<p>Арга хэмжээ-7: Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, жуулчдад зориулсан арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах</p>	-	1,699,106 хандалтын тоо	1,699.1	1,800.0	<p>Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ жуулчдад зориулан зохион байгуулсан үзэсгэлэн, эвент арга хэмжээнүүдийн талаар МҮОНРТ, UBS, TV5, Eagle зэрэг 10 телевиз, News.mn, Gogo.mn, Zarig.mn, Eguur.mn, Ikom.mn зэрэг 18 сайт, Өдрийн сонин, Өнөөдөр, Монголын мэдээ зэрэг 5 сонин зэрэг хэвлэл мэдээллийн 30 гаруй байгууллагаар 10 удаагийн ярилцлага, нэвтрүүлэг, 22 мэдээ мэдээллийг түгээж, мөн “Дэлхийн Монголчуудын MGL” радиогийн Дөрвөн зүгийн шуугиан, Өдөр тутмын мэдээ, Пин пост буланд 11 эвент, арга хэмжээний талаар цуврал мэдээ мэдээлэл нийтлүүлж үйл ажиллагаагаа сурталчлан ажилласан. Мөн байгууллагын</p>	90

						www.tourism.ub.gov.mn www.visitulaanbaatar.net цахим хуудас болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд 2832 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг байршуулж 1,659,489 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлан ажиллалаа.	
2.3	Арга хэмжээ-8: Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан арга хэмжээг Эй Ар, Ви Ар, (AR,VR) технологиор хийж сурталчлах	-	Бүтээгдэхүүн үйлчилгээний тоо	-	2	Улаанбаатар хотын зорин очих газрууд, хотын аяллын маршрут, жуулчдад зориулсан аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг Эй Ар, Ви Ар (AR, VR) орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан жуулчдад хүргэх зорилгоор “AR Mongolia” “Digital solution”, “Тэнгис бука” зэрэг байгууллагуудаас үнийн санал авч бүтээгдэхүүний судалгааны ажлыг зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын шийдвэрээр AR, VR технологийг нэвтрүүлэх ажлыг хойшлуулсан.	50
2.4	Арга хэмжээ-9: Жуулчдад зориулсан гар утасны аппликейшн хөгжүүлэх	-	Аппликейшны тоо	-	1	1.Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг нэг дороос хэрэгцээт мэдээ мэдээлэлээр хангах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах зорилгоор “Visit Ulaanbaatar” гар утасны аппликейшны хөгжүүлэлтийг хийж Улаанбаатар хотын зорин очих газрууд, жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд, үзвэр, үйлчилгээний газруудын мэдээлэл, хаяг байршил болон эвент арга хэмжээ зэрэг 5 катологийн нийт 90 гаруй мэдээ, мэдээллийг байршуулж монгол, англи хэл дээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. 2.Улаанбаатар хотын автобустай аяллын “ub-pass” вэб сайтад суурилан бүтээгдэхүүн, үйлчилгээг 2024 оны 07	100

						дугаар сарын 01-ний өдрөөс нэвтрүүлэн 270 жуулчин бүтээгдэхүүн үйлчилгээ авсан бөгөөд “ub-pass” гар утасны аппликейшны хөгжүүлэлтийг хийж байна.	
2.5	Арга хэмжээ-10: Дэлхийн аялал жуулчлалын хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100	<p>1. Улаанбаатар хот Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоонд (World Tourism Cities Federation) 2022 онд элссэн. Холбооны https://en.wtcf.org.cn/ цахим хуудаст Улаанбаатар хотын танилцуулга, зохион байгуулдаг эвент арга хэмжээнүүдийн видео танилцуулга, зургийн цомгийг байршуулж WTCF-ийн хот, байгууллагуудын гишүүд болон олон нийтэд сурталчилсан.</p> <p>2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санаачилгаар Зүүн хойд Азийн хотуудын өмнө тулгарч байгаа асуудлуудыг хэлэлцэж харилцан туршлага солилцох, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор VI дахь удаагийн Зүүн хойд Азийн хотын дарга нарын чуулга уулзалт олон улсын арга хэмжээг “Зүүн хойд Азийн хотуудын тогтвортой хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжин хэрэгжүүлэх нь” сэдвийн хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдав. Чуулга уулзалтын салбар хуралдаан “Эдийн засгийн өсөлтөд аялал жуулчлал, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжин ажиллах нь” сэдвийн дор зохион байгуулагдаж “Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбоо”-ны гишүүн хотуудын дарга нарын төлөөлөл оролцлоо.</p>	100

2.6	<p>Арга хэмжээ-11: Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор олон улсын үзэсгэлэн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах</p>	Нийслэлийн төсөв 172.9	Оролцсон, зохион байгуулсан арга хэмжээний тоо	13	8	<p>“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, тур оператор компаниудтай хамтран олон улсын 7 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож, 3 арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ ХБНГУ-ын Берлин хотноо 2024 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 58 дахь удаагийн “ITB BERLIN-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ✓ Улаанбаатар хотноо 2024 оны 04 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “TOURISM WEEK” олон улсын аялал жуулчлалын чуулган, ✓ БНСУ-ын Сөүл хотноо 2024 оны 05 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 39 дэх удаагийн “SEOUL INTERNATIONAL TRAVEL FAIR- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ✓ Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатар тревел экспо-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ✓ Тайвань улсад 2024 оны 07 дугаар сарын 04-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Эко аялал жуулчлал” олон улсын зөвлөгөөн, 	100
-----	--	---------------------------	--	----	---	---	-----

						<ul style="list-style-type: none"> ✓ Япон улсын Токио хотноо 2024 оны 09 сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “TRAVEL EXPO JAPAN-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ✓ Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “ITM- МОНГОЛИА-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, ✓ БНХАУ-ын Гуан-жоу, Хонконг, Бээжин хотуудад 2024 оны 04 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд “GO MONGOLIA-ROAD SHOW 2024” арга хэмжээг хамтран зохион байгууллаа. <p>“SEOUL INTERNATIOL TRAVEL FAIR-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улс “GO MONGOLIA” аялал жуулчлалын брэндийгээ сурталчлан танилцуулж “Шилдэг PR маркетингтай” оролцогчоор, “ITM Монголиа-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь “Шилдэг тохижилттой” оролцогчоор шалгарлаа.</p>	
2.7	Арга хэмжээ-12: Найрамдалт харилцаат хотуудад Улаанбаатар хотыг сурталчлах соёл урлаг, аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах	Нийслэлийн төсөв 70.0	Арга хэмжээний тоо	-	1	Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын яам, Монгол Улсаас БНХАУ суугаа Элчин сайдын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, “Хүннү Айр” ХХК хамтран “GO MONGOLIA” ROAD SHOW-2024 арга хэмжээг БНХАУ-ын Гуан-жоу, Хонгконг, Бээжин зэрэг 3 хотод 2024 оны 04 дүгээр сарын 25-29-	100

						ний өдрүүдэд зохион байгуулж арга хэмжээнүүдийн үеэр 2024 онд Монгол Улс, Улаанбаатар хотод зохион байгуулагдах олон улс болон үндэсний хэмжээний чанартай эвент арга хэмжээний нэгдсэн танилцуулгыг хүргэж, Улаанбаатар театрын уран бүтээлчид үндэсний урлагийн тоглолтоо зохион байгуулав.	
2.8	Арга хэмжээ-13: Найрамдалт харилцаат хотуудын аялал жуулчлал, соёл урлагийн өдрүүдийг Улаанбаатар хотод зохион байгуулах	Нийслэлийн төсөв 90.2	Арга хэмжээний тоо	4	3	Найрамдалт харилцаат улс, хотуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, бэхжүүлэх зорилгоор “Францын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, “Японы соёл, аялал жуулчлалын өдөрлөг” (Japan festival) арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 24,25-ны өдрүүдэд, “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” (Korea Week) арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулж, арга хэмжээнүүдэд 96 зочид төлөөлөгчид, 200 гаруй уран бүтээлчид, 270 гаруй жуулчид зорин ирж оролцлоо. Арга хэмжээнүүдийг гадаад, дотоодын нийт 48,000 гаруй хүн үзэж сонирхсон.	100
3.	Зорилт 3: Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.3						
3.1	Арга хэмжээ-14: Жуулчдад хэрэгцээт мэдээ, мэдээллийг хүргэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор “Оюутан цагдаа” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Нийслэлийн ГХУССЗ-ийн зардал 160.0	Үйлчилгээ үзүүлсэн гадаад жуулчдын тоо	7666	8000	Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэднийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Оюутны холбоо хамтран “Оюутан цагдаа-2024” арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 13-ны	100

						<p>өдрөөс 08 дугаар сарын 13-ны өдрийн хооронд 2 сарын хугацаанд хэрэгжүүлэн Улаанбаатар хотын 14 их, дээд сургуулийн 50 оюутан ажиллалаа. Оюутан цагдаа нар ажиллах хугацаандаа Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт гэмт хэргийн 13, зөрчлийн шинжтэй 3213 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 16,178 иргэнд туслалцаа үзүүлэн, гадаадын 17,255 иргэнд хэлмэрчилж, 5 төрлийн 20,500 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, 2600 хүүхдэд эцэг эхийн утасны дугаар бүхий бугуйвч зүүж, эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 136 бага насны хүүхдийг ар гэрт нь, 5 хүүхдийг Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, Монгол орны байгалийн дурсгалт болон түүх соёлын дурсгалт газар, үзвэр үйлчилгээний талаар 5 бүлэг 58 мэдээ, мэдээлэл бүхий QR кодыг гадаадын 16,981 жуулчдад танилцуулан ажилласан.</p>	
3.2	<p>Арга хэмжээ-15: Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтийг сайжруулах ажлын хүрээнд зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад хяналт тавих, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх замаар и-баримтад холбох ажлыг хамтран зохион байгуулж, нийслэл хотын албан татварт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх</p>	-	<p>Нийслэл хотын албан татварт төвлөрүүлэх мөнгөн дүн</p>	12,736,167.1	16,000,000.0	<p>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ын хүрээнд “Онлайн бизнес төв” нэгдсэн системд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудын бүртгэлийг нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Нийслэл хотын албан татварт 26,506.5 (хорин зургаан тэрбум таван зуун зургаан сая таван зуун мянга) төгрөгийн татварын орлого төвлөрсөн байна.</p>	100

3.3	<p>Арга хэмжээ-16: Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний байгууллага зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартын үзлэг зохион байгуулах</p>	-	Байгууллагын тоо	243	44	<p>Аялал жуулчлалын байр сууцаар хангах үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, үндэсний болон хотын стандартуудын хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран үзлэг, хяналт шалгалтын ажлыг 2 удаа зохион байгуулж 105 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулав.</p> <p>Үүнд: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/146 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг 2024 оны 05 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд Богдхан Уулын тусгай хамгаалалтай газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газруудад үйл ажиллагаа эрхэлдэг 29 амралтын газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт, Нийслэлийн Байгаль орчны газар, Туул голын сав газрын захиргаатай хамтран “Нийслэлийн ногоон бүс, усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрүүдэд 76 амралтын газар, жуулчны баазуудын үйл ажиллагаанд стандартын үзлэг, хяналт, шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>	100
3.4	<p>Арга хэмжээ-17: Үндэсний болон хотын стандартуудыг иргэд, олон</p>	-	Цахимаар үзсэн хүний тоо	-	120,000	<p>“Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага”MNS6043:2019, “Зочид буудалд тавих ерөнхий шаардлага</p>	100

	нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах					MNS 4588:2008”, “Аялал жуулчлал.Дэн буудлын ерөнхий шаардлага MNS 5738:2007”, “Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага UCS1203:2022”, “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” UCS1401B:2022”, “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” UCS1706A:2022” стандартуудыг “Улаанбаатар хотын амралтын газар, жуулчны баазуудын нэгдсэн мэдээ, мэдээлэл”, “Улаанбаатар хотын Зочид буудлуудын нэгдсэн мэдээлэл” зэрэг пэйж хуудаснуудад байршуулж 135,300 гаруй хүнд хүргэсэн.	
3.5	Арга хэмжээ-18: Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр болон олон улсын туршлагыг судлах, экспертийн төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулах	Нийслэлийн төсөв 295.1	Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо	647	700	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Гастро аялал-2024” олон улсын хоолны тогооч бэлтгэх сургалт, “Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалт”, “Чингис хаан Үндэсний музейд тайлбар хийх эрх олгох” сургалт, “Олон улсын эксперт багштай зочлох үйлчилгээний сургалт”, “Оюутан цагдаа-2024 үйл ажиллагааны сургалт”, “Олон улсын хоолны жор технологи” сургалт зэрэг гадаад, дотоодын 6 төрлийн 18 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 865 хүнийг хамруулав.	100

3.6	Арга хэмжээ-19: Улаанбаатар хотын аялал жуулчлалын мэдээллийн санг хөтлөх	-	Мэдээллийн сангийн бүрдэл	-	7	Аялал жуулчлалын мэдээллийн сан хөтлөх арга хэмжээний хүрээнд салбарын хүний нөөцийн мэдээлэл, дотоодын болон олон улсын жуулчны тоон мэдээлэл, аялал жуулчлалын байгууллагын бүртгэл мэдээлэл, аялал жуулчлалын бүс, маршрутын мэдээлэл, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээлэл, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын мэдээлэл зэрэг бүлгүүдийн хүрээнд төрөлжүүлэн 15 ангиллаар 10.000 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.Үүнд: ✓ Зочид буудал, амралт, сувиллын газруудын мэдээлэл ✓ Түүхэн дурсгалт барилга байгууламж, хөшөө дурсгалын тайлбар ✓ Тур оператор, Аялал жуулчлалын байгууллагуудын мэдээлэл ✓ Музей үзмэрийн газруудын мэдээллүүд ✓ Нийтийн тээвэр, хот хоорондын зорчигч тээврийн мэдээлэл ✓ Ресторан зоогийн газар, кофе шопын мэдээлэл ✓ Цагдаа, эмнэлэг, элчин сайдуудын яамдын хаяг, байршил	100
4.	Зорилт 4: “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлнэ. НЗДҮАХ-3.4.4						
4.1	Арга хэмжээ-20: “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	80.0	85.0	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599 дүгээр захирамжаар батлуулсан Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг хэрэгжүүлэх 7 зорилтын 77 арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.	90

5.	Зорилт 5: Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:						
5.1	<p>Арга хэмжээ-21: Улс, нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд санал боловсруулж хүргүүлэх, байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж тогтоосон хугацаанд тайлагнах</p>	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	95.3	95.0	<p>1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах 1 зорилтын 6 арга хэмжээний санал, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгах 2 зорилтын 14 арга хэмжээний санал, Нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын 1 төсөл, зорилт, Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны хөгжлийн баримт бичигт тусгах 3 төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж холбогдох газруудад хүргүүлсэн.</p> <p>2.Улс, нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт (эхний хагас жил) 88,0 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1 зорилт 1 арга хэмжээний биелэлт 100 хувь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5 зорилтын 10 арга хэмжээний биелэлт 97,2 хувь, Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 1 зорилтын 18 арга хэмжээний хэрэгжилт (III улирал) 87,0</p>	100

						хувь, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан гэрээний хүрээнд Нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2024 онд хэрэгжүүлэх 2 зорилтын 10 арга хэмжээний хэрэгжилт 89,0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тогтоосон хугацаанд тайлагнаж ажилласан.	
5.2	Арга хэмжээ-22: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн холбогдох заалтыг хяналтад бүртгэж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	94.0	95.0	Байгууллагын чиг үүрэгт хамаарах Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 9 заалт, Нийслэлийн Засаг даргын 32 захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн 11 заалтыг байгууллагын хяналтад бүртгэж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг мэдээг сар бүр тайлагнаж биелэлт 98,8 хувь, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 96.6 хувь (III улирал), Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 94.5 хувийн (III улирал) гүйцэтгэлтэй хэрэгжиж тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнасан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Худалдан авах ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 01, “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган биелэлт 2024 оны III улирлын байдлаар 85.0 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
5.3	Арга хэмжээ-23: Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хууль тогтоомж,	-	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн	8	10	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,	100

	<p>тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх</p>		<p>баримт бичгийн тоо</p>			<p>захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хүрээнд бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд: “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт (эхний хагас жил) 88,0 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1 зорилт 1 арга хэмжээний биелэлт 100 хувь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5 зорилтын 10 арга хэмжээний биелэлт 97,2 хувь, Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 1 зорилтын 18 арга хэмжээний хэрэгжилт (III улирал) 87,0 хувь, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан гэрээний хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх 2 зорилтын 10 арга хэмжээний хэрэгжилт 89,0 хувь, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 98,8 хувь, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 96.6 хувь (III улирал), Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 94.5 хувийн (III улирал) гүйцэтгэлтэй хэрэгжсэн.</p>	
--	--	--	---------------------------	--	--	---	--

5.4	<p>Арга хэмжээ-24: “Албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж хэрэгжилтийг хангах</p>	Байгууллагын төсөв 5.8	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	95.0	100	<p>1.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 55 удаагийн сургалтад давхардсан тоогоор 235 албан хаагч, 7 удаагийн хэлэлцүүлэг, зөвлөгөөнд давхардсан тоогоор 34 албан хаагчийг хамруулав. Тухайлбал: Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын зорилтод сургалтад 3 албан хаагч, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 16 удаагийн сургалтад 144 албан хаагч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан богино хугацааны 5 удаагийн сургалтад 10 албан хаагч, байгууллагаас зохион байгуулсан 14 удаагийн сургалтад давхардсан тоогоор 52 албан хаагч хамрагдсан.</p> <p>2.Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын дагуу 3 албан хаагчид нэмэгдэл цалин, 16 албан хаагчид ажлын гүйцэтгэлийн урамшуулал, 12 албан хаагчид ээлжийн амралтын цалин, давхардсан тоогоор 32 албан хаагчид илүү цаг ажилласан нэмэгдэл хөлс олгож, хүний нөөцийн нэгдсэн систем https://hrm.csc.gov.mn/ системд албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тогтмол шинэчлэн 4 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл, 1 албан хаагчийн төрийн албаны тангаргийг өргүүлсэн. Мөн АШУҮИС-</p>	90
-----	---	---------------------------	-----------------------------------	------	-----	---	----

						ийн Монгол-Японы эмнэлэгтэй хамтран 10 албан хаагчийг эрүүл мэндийн багц үзлэг шинжилгээнд хамруулж, Олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан албан хаагчдын 36 хүүхдэд хүндэтгэл үзүүлж, төрийн одон медалиар шагнагдсан 1 албан хаагчид мөнгөн шагнал олгож, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулан шинээр 15 ширхэг суурин компьютер, 2 принтер олгуулсан.	
5.5	Арга хэмжээ-25: Хүний нөөцийн ил тод байдлыг ханган сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн жинхэнэ албан хаагчийн удирдах (нэгжийн дарга) 1 албан тушаал, гүйцэтгэх 1 албан тушаал нийт 2 албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, нэр дэвшүүлсэн албан хаагчдаас сул орон тоог нөхөх ажлыг зохион байгууллаа.	100
5.6	Арга хэмжээ-26: Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	1.Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хороо, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сангаас “НАДААС, ТАНААС, БИДНЭЭС ЭХЛЭЛТЭЙ” уриатайгаар 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Харилцан Хүндэтгэе” үндэсний хэмжээний 1 сарын аян, “ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ-Шалтаг бүү тооч” уриа дор 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс зохион байгуулж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” 16 хоногийн аянд нийслэлийн Аялал жуулчлалын	100

						<p>газрын хамт олон нэгдэж 6 удаагийн баннер, бичлэгийг байгууллагынхаа цахим хуудсаар дамжуулан 8,000 гаруй хүнд хүргэсэн. Мөн жендерийн эрх тэгш байдлыг хангах, албан хаагчдын мэдлэг, мэдээллийг сайжруулах зорилгоор “Жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт” сэдэвт сургалтад 2, “Жендэр ба аялал жуулчлал” хэлэлцүүлэгт 8 албан хаагч хамрагдсан.</p> <p>2.Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын дагуу 12 албан хаагчид хүүхдээ хичээл, сургуульд нь хүргэж өгөх ажлын цагийн зохицуулалт хийж, мөн нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд болон тэмдэглэлт өдрүүд, амралтын өдрүүдэд ажилласан нийт 32 (давхардсан тоогоор) албан хаагчдад илүү цаг ажилласан нэмэгдэл хөлсийг тооцон олгож, долоо хоногийн нэг өдөр цахимаар ажиллуулж байна.</p>	
5.7	<p>Арга хэмжээ-27: Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг ханган, хүнд суртлыг багасгаж, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэн ажиллах</p>	-	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100	100	<p>“Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:</p> <p>1.Авлигаас урьдчилан сэргийлэх “АВЛИГААС ТАТГАЛЗАХ БОЛОМЖ БИДЭНД БИЙ”, “АВЛИГАД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЦГЭЭЭ”, авлигын эсрэг үйлдлийг “110 УТАС РУУ ҮНЭГҮЙ ЗАЛГАХ БОЛОМЖТОЙ” 2 төрлийн баннерыг байгууллагын цахим хуудас болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын 3 төрлийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 12 төрлийн танилцуулга, баннер, зурагт хуудсыг</p>	90

						<p>жанжин Д.Сүхбаатарын талбай, Төв шуудан, Хөшгийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудалд байрлах жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдээр дамжуулан иргэдэд тарааж, авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн буланг сар бүр тогтмол шинэчлэн, авлига,</p> <p>2.Албан хаагчдын ёс зүйн зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 12 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 71 албан хаагчийг хамруулав.</p> <p>3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 14 албан хаагч хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаандаа тайлагнаж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн дүгнэлтийг үндэслэн 5 албан хаагчийг томилж, үнэлгээний хороонд ажилласан 2 албан хаагчаас “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргуулан цахим бүртгэлийг үүсгэсэн.</p>	
5.8	<p>Арга хэмжээ-28: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллаж төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнах</p>	Байгууллагын төсөв 695.0	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	<p>1.Байгууллагын 2024 оны төсөвт бичиг хэргийн зардалд 1,466,000 төгрөг, тээвэр шатахууны зардалд 16,896,000 төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 5,160,000 төгрөг нийт 23,522,000 батлагдаж 2024 оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар бичиг хэргийн зардалд 1,001,460 төгрөг, тээвэр шатахууны зардалд 6,273,500 төгрөг, шуудан холбоо, интернэтийн</p>	100

						<p>төлбөрт 1,963,465.02 төгрөг нийт 9,238,425.02 төгрөг зарцуулж санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж санхүүгийн тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь тайлагнаж, шинээр авлага, өр төлбөр үүсгээгүй, он дамжсан, насжилт өндөртэй өр, авлага үүсгээгүй.</p> <p>2.Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэг, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд байгууллагын нэмэлт дансанд нийслэлийн төсвөөр санхүүжиж эвент арга хэмжээ зохион байгуулахад 959,532.4 төгрөг, сургалт зохион байгуулахад 264,160.0 төгрөг, маркетинг, сурталчилгаа, хамтын ажиллагааны чиглэлээр 695,372.4 төгрөгийг батлуулж гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн баримтын бүрдлийг тухай бүр хангуулан тайлагнан ажиллав.</p>	
5.9	<p>Арга хэмжээ-29: Байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх</p>	-	Орлого бүрдүүлэлт	30,081,0	35,000.0	<p>Байгууллагын 2024 оны төсөвт туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 35,000,000 (гучин таван сая) төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр батлагдсан. “Сити тур” төслийг хэрэгжүүлэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн хуваарийн дагуу 2024 оны 05 сараас эхлэн хэрэгжүүлэн 36,280,000 (гучин зургаан сая хоёр зуун наян мянга) төгрөгийн орлогыг төвлөрүүлж (хүлээгдэж буй гүйцэтгэлээр) төлөвлөгөөний биелэлт 103,5 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	100
5.10	<p>Арга хэмжээ-30: Байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран</p>	-	Хэрэгжилт, хувиар	100	100	<p>Нийслэлийн Өмчийн харилцааны газартай “Нийслэлийн өмч эзэмшүүлэх</p>	100

	зарцуулах аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэлийг ханган ажиллах					гэрээ"-г шинэчлэн байгуулж гэрээний биелэлтийн ханган ажиллаж байна. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаалаар байгууллагын 2024 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг санхүүгийн программ дах дансанд бүртгэлтэй тулган тооллогоор 192 нэр төрлийн 34,000 ширхэг 306,588,631.00 төгрөгийн үндсэн хөрөнгө, 286 төрлийн 117,250,958.45 төгрөгийн бараа материалд тооллого явуулж тайлан мэдээг хугацаанд нь Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлэв.	
5.11	Арга хэмжээ-31: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн ил тод байдлыг ханган цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийг үнэн зөв тогтоосон хугацаанд байршуулах	-	Хэрэгжилт, хувиар	100	100	Шилэн дансны тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж www.info.shilendans.gov.mn цахим санд байгууллагын жилийн төсөв, гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн тайлан, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд байршуулан тайлагнаж, үндсэн болон нэмэлтээр санхүүжсэн үйл ажиллагааны чиглэлээр 41, үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааны чиглэлээр 55, бусад чиглэлээр 36 буюу 122 ажил, арга хэмжээний мэдээ мэдээллийг тухай бүр байршуулж ил тод байдлыг ханган ажилласан.	100
5.12	Арга хэмжээ-32: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг ханган төсвийн хөрөнгө оруулалтын төсөл,	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100	Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 2024 онд 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/476 дугаар захирамжаар Үндэсний онцлог бүхий	100

	арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь чанартай зохион байгуулах					жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Аялал жуулчлалын газарт шилжүүлсэнтэй холбогдуулан НХААГ/20240101317 дугаартай худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн амжилттай зохион байгууллаа.	
5.13	Арга хэмжээ-33: Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар, бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	Нийслэлийн удирдах ажилтнуудын 17 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс байгууллагын чиг үүрэгт хамаарах 51 үүрэг даалгаврын биелэлтийг заалт тус бүрээр бүрэн ханган хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь https://erp.ulaanbaatar.mn/ программын Хяналт шинжилгээ, үнэлгээний дэд системээр тайлагнаж, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хуулийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ, мэдээлэл, судалгааг цаг хугацаанд нь хүргүүлж, нийслэлийн удирдлагуудаас холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн тайлагнан ажилласан.	100
6.	Зорилт 6: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:						
6.1	Арга хэмжээ-34: Үйлчилгээ эрхлэх бүртгэл “Онлайн бизнес төв” цахим системээр ирүүлсэн хүсэлтийг хянан шийдвэрлэх	-	Шийдвэрлэлтийн хувь	80.0	100.0	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ыг хүрээнд нийслэлийн https://www.ulaanbaatar.mn/ портал системийн “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл” цэсэд 310 иргэн, хуулийн этгээд зочид	100

						буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр бүртгүүлж хүсэлтийг тухай бүр хянан шийдвэрлэсэн.	
6.2	Арга хэмжээ-35: Албан хэрэг хөтлөлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх	-	Шийдвэрлэлтийн хувиар	99	100	Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хариутай 102 албан бичиг, хариугүй 280 албан бичиг нийт 382 албан бичгийг бүртгэж, 452 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу боловсруулан явуулсан. Ирүүлсэн 382 албан бичгээс 374 албан бичгийг эцэслэн шийдвэрлэж, 8 албан бичиг судалж байгаа төлөвтэй. Албан бичгийн шийдвэрлэлт 99.96 хувийн үзүүлэлттэй байна.	100
6.3	Арга хэмжээ-36: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэх	-	Шийдвэрлэлтийн хугацаагаар	5 хоног	5 хоног	Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар нийт 15 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100% эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 19 цаг 35 минут байна.	100
6.4	Арга хэмжээ-37: “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2023 оны архивын материалыг хүлээн авах, архивын баримтын нэгдсэн данс бүртгэл хөтлөх	-	Хадгаламжийн нэгжийн тоо	157	160	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2023 оны байнга хадгалах 66, түр хадгалах 71, 70 жил хадгалах 3, тусгай төрлийн 20 нийт 160 баримтыг архивын баримтын нэгдсэн данс бүртгэл хөтөлж хадгаламжийн нэгж үүсгэсэн.	100

6.5	<p>Арга хэмжээ-38: Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг гадаад, дотоодын иргэдээс авч, түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах</p>	-	Судалгааны тоо	2	3	<p>Байгууллагын үндсэн чиг хүрээнд тогтмол зохион байгуулдаг эвент арга хэмжээнүүдийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, оролцогчдын сэтгэл ханамжийг үнэлэх, эдийн засгийн үр ашигт таамаглал дэвшүүлэх, эвентийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нөлөөлж буй сэдэлжүүлэлт, нийгэм-эдийн засгийн үр ашигт байдлыг үнэлэх зорилгоор Санхүү Эдийн Засгийн Их сургуулийн Олон улсын аялал жуулчлалын сургалт, судалгааны институттай хамтран “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Талын салхи” олон улсын мото наадам, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд фестиваль” зэрэг 7 эвент арга хэмжээний судалгааны ажлыг зохион байгуулж гадаадын 502, дотоодын 1494, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ эрхлэгч 288, худалдаа үйлчилгээ эрхлэгч 407 нийт 2691 хүнээс судалгаа авч, арга хэмжээнүүдийг гадаад, дотоодын нийт 173,000 гаруй хүн үзэж сонирхон. Улаанбаатар хотын эдийн засагт 16.036.000.000 тэрбум төгрөгийг эргэлтэд оруулсан байна.</p>	100
6.6	<p>Арга хэмжээ-39: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын цахим хуудсанд хууль тогтоомжоор хүлээсэн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, тайлан холбогдох цаг үеийн мэдээ, мэдээллийг нээлтэй байршуулах</p>	-	Байршуулсан мэдээ, мэдээллийн тоо	2382	2500	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллүүдийн хүрээнд байгууллагын зорилго зорилт, үндсэн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, албан хаагчдын мэдээлэл, төрийн үйлчилгээ болон хүний нөөц, санхүүгийн ил тод байдал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үйл</p>	100

					<p>ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол шинэчлэн ажилласан.</p> <p>Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, арга хэмжээнүүдийг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд 2832 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 1,659,489 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан.</p> <p>Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> ✓ www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 450 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 114,000, ✓ www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 97 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 43,710 ✓ https://www.facebook.com/UlaanbaatarTourism цахим хуудсанд 576 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 34,000 хандалтын тоо 1,400,580 ✓ https://www.instagram.com/visit.ulaanbaatar/ цахим хуудсанд 150 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 324, хандалтын тоо 60,870 ✓ https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpdZzieEnhXfPFA цахим хуудсанд 34 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 422, хандалтын тоо 75,700 байна.
--	--	--	--	--	---

7.	Зорилт 7: Тохижилт-Бүтээн байгуулалтын жилийн хүрээнд:						
7.1	Арга хэмжээ-40: “Хүннүгийн язгууртны цогцолбор” түүх, соёлын дурсгалт газар орчмын тохижилтын ажлыг хийж дуусгах	Нийслэлийн төсөв 173.4	Тохижилтын ажлын явц, хувиар	80	100	Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах зорилтын хүрээнд Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны булш” цогцолборын тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, 800 м урт хашаа, 21 амрах сандал, 8 сүүдрэвчтэй ширээ, 60 м.кв талбай бүхий ариун цэврийн байгууламж, бохирын байгууламж болон 1500 м урт явган хүний зам, 7 амрах цэг, 1400 м.кв талбай бүхий авто машины зогсоол, угтах хаалга зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлэв.	100
7.2	Арга хэмжээ-41: Жуулчин төгөл байгуулах “Нэг жуулчин-нэг мод” төслийг үргэлжлүүлэх	Хувийн хэвшлийн хөрөнгө 16.0	Тарьсан модны тоо	230	250	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Цолмон трэйвел” ХХК, Монголын Аялал жуулчлалын холбоо хамтран Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Жуулчин төгөл” байгуулах ажлыг 2022 онд эхлүүлж 18 төрлийн 610 мод, бут сөөг тарьж суулгасан. “Ногоон хот-Иргэний оролцоо-2024” уриан дор зохион байгуулагдсан хаврын мод тарих арга хэмжээний хүрээнд “Жуулчин төгөл”-д тарьсан модны арчилгаа, цэнэг усалгаа нөхөн тарилтыг хийх, шинээр мод тарих ажлыг 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж 180 мод тарьж, мөн дэлхийн аялал жуулчлалын өдөр, Монгол Улсад аялал жуулчлалын салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тохиолдуулан 2024 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр аялал жуулчлалын салбарын 30 гаруй байгууллагатай хамтран 10 төрлийн 326 мод, бут, сөөг тарих ажлыг зохион	100

						байгуулав. Үндэсний хөдөлгөөний хүрээнд “Жуулчин төгөл”-д нийт 27 төрлийн 1116 мод, бут сөөг тариад байна.	
7.3	Арга хэмжээ-42: Амралтын газар, жуулчны баазуудын гадна орчны тохижилт, бие засах газруудыг үндэсний болон хотын стандартын дагуу шинэчлүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	-	Аж ахуйн нэгжийн тоо	-	10	“Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага UCS1203:2022”, “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” UCS1401B:2022”, “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” UCS1706A:2022” стандартуудын “Улаанбаатар хотын амралтын газар, жуулчны баазуудын нэгдсэн мэдээ, мэдээлэл” нэгдсэн цахим хуудсаар дамжуулан сурталчилж, 76 амралтын газар, жуулчны баазад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 15 амралтын газар хотын стандартын дагуу бие засах газруудаа шинэчилэн тохижуулсан.	100
7.4	Арга хэмжээ-43: Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад орчны тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр уриалга гарган хүргүүлж хамтарч ажиллах	-	Аж ахуйн нэгжийн тоо	-	50	“Тохижилт-Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аялал жуулчлалын байр сууцаар хангах үйлчилгээний байгууллагуудын орчны тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр 418 зочид буудал, дэн буудал, 187 амралтын газар, жуулчны баазуудад 2024 оны 04 сарын 05-ны өдрийн “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээнд оролцох тухай” 01/125 дугаартай албан бичиг, 2024 оны 04 сарын 30-ны өдрийн “Уриалга хүргүүлэх тухай” 01/165 дугаартай албан бичгийг хүргүүлж, 120 гаруй аж ахуйн нэгж, байгууллага орчиндоо	100


						тохижилт хийж, зүлэг, мод, бут сөөг тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүлсэн.
Нийт дундаж 97,2 хувь						

ТАНИЛЦСАН:
ДАРГА




Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА




Д.ГАНБОЛД

ТАЙЛАН БОЛОВСРУУЛЖ НЭГТГЭСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН



О.НЯМБАТ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
СУРГАЛТ, СУДАЛГАА, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Ч.ЭНХ-ОТГОН